



ДАРХАН-УУЛ АЙМАГ
“ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 9/63

Дархан

“ДДС” ТӨХК-нд хэрэгжүүлэх
“Хүүхэд хамгааллын бодлого”,
“Эцэг эхийн зөвлөл”-ийн ажиллах
журам батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь заалт, “Хүүхэд хамгааллын тухай” хуулийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанид хэрэгжүүлэх “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Компанид мөрдөх “Эцэг эхийн зөвлөл”-ийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Энэ тушаалыг 2025 оны 03 дүгээр сарын 10-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Д. БАТЖАРГАЛ



452501232

Гүйцэтгэх захирлын 20²⁵ оны 03 дүгээр
сарын 10-ний өдрийн 9/63 дугаар
тушаалын хавсралт

"ДДС" ТӨХК-нд ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. "ДДС"ТӨХК нь хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын жишиг бодлого, Эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасны дагуу ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн дотоод журамд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.

1.2. Ажилтан, албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд чиглэсэн сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллана.

Хоёр. Үндсэн зарчмууд

2.1. Хүүхдийн эрх, язгуур эрх ашиг, тэдний аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн үзнэ.

2.2. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй.

2.3. Компанийн үйл ажиллагаанд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, үл хайхрах байдал, осол гэмтэлд өртүүлж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллана.

Гурав. Хамрах хүрээ

3.1. Энэхүү баримт бичиг нь компанийн үндсэн болон гэрээт ажилтан, албан хаагч ажилтнуудад хамаарна.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1. Захиргаа нь ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөрийн харилцааны уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангах.

4.2. Цэцэрлэгийн болон бага ангийн хүүхэдтэй ажилтан, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай өрхийн гишүүнтэй ажилтан, өрх толгойлсон эцэг, эхийн ажиллах нөхцөлийг уян хатан болгож хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгуулж, мөрдүүлнэ. Үүнд:

4.2.1. богиносгосон цагаар ажиллах;

4.2.2. цахимаар ажиллах;

4.2.3. хүүхдээ цэцэрлэг, сургуульд хүргэж өгөх, авах боломжоор хангах;

4.2.4. шөнийн ээлжийн ажилд аль болох хуваарилахгүй байх;

4.2.5. цалингийн нэмэлт, урамшуулал дэмжлэг үзүүлэх;

4.2.6. бусад дэмжлэгт хамруулах.

4.3 Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг", "Байгууллагад эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж"-ийн дагуу байгууллага, ажилтнуудын гэр бүл, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааг байгууллагын нөөц, хэрэгцээнд түшиглэн зохион байгуулах "Эцэг эхийн зөвлөл" /цаашид Зөвлөл гэх/-ийг байгуулах. Үүнд.

4.3.1. Зөвлөл нь ажилтнуудаас саналыг авч, хэлэлцэн төлөвлөгөөг 1 жилийн хугацаатайгаар гарган, батлуулах бөгөөд биелэлтийг байгууллагын удирдлага, нийт хамт олонд тайлагнах;

4.3.2. Байгууллагын мэдээллийн самбар цахим хуудаст байршуулж, сурталчлан таниулах;

4.3.3. Байгууллагын ажилтан, албан хаагчийн гэр бүл, хүүхдийн нөхцөл байдлын судалгаа хийж, хэрэгцээнд суурилсан сургалт, бодит дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн байгууллагын үйлчилгээнд холбон зуучлах.

4.4. Ажилтан албан хаагчиддаа зориулж сургалт нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

4.4.1 Ажилтан, албан хаагчийн хүүхдийн сурч боловсрох, хөгжил, хамгааллыг дэмжих, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олон болох санаачилгыг өрнүүлэх;

4.4.2. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ажилтан, албан хаагч, тэдний гэр бүл, хүүхдэд зориулсан соён гэгээрүүлэх, хөгжүүлэх, чадавхжуулах сургалт, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулах.

4.4.3. Компанийн боломж, ажилтнуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн санал санаачилгыг өрнүүлж байгууллагын нөөцөд тулгуурлан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

Тав. Ажилтнуудын хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм

5.1. Байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагч бүр ажлын байр, гэр бүл, нийгмийн бүхий л орчинд зохисгүй зан үйл гаргахгүй байхад анхаарч, хүүхэд хамгааллын ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

5.2 Байгууллагын аливаа үйл ажиллагаанд хүүхдийн эрхийг зөрчсөн дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Үүнд:

5.2.1. Хүүхэд хамгааллын бодлогыг зөрчиж байгаа нь мэдэгдсэн, сэжиглэгдсэн боловч мэдээгүй мэт өнгөрөөх, нуун дарагдуулах

5.2.2. Хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан боловч мэдээлэхгүй байх

5.2.3. Хүүхдийг ямар нэгэн хөдөлмөрт хөлслөх

5.2.4. Ажилтан бүр насанд хүрээгүй хүүхдээр өөрийн хүүхдийг асруулах, гэрийн үйлчлэгч хийлгэх, хувийн бизнестээ олон цагаар туслуулах

5.2.5. Оройн 18 цагаас хойших арга хэмжээнд хүүхэд оролцуулах

5.2.6. Эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй хүүхдийг урлаг, спортын үйл ажиллагаанд оролцуулах

5.2.7. Гамшиг осол, уй гашуу тохиолдсон үед хүүхэд, насанд хүрэгчдийн эмзэг байдалд мэдрэмжгүй хандах

5.2.8. Эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийг ганцааранг нь машинаар авч явах

5.2.9. Хүүхдийг ёс заншил, шашны болон зан үйлийн хэлбэртэй үйл ажиллагаанд оролцуулах

- 5.2.10 Хүүхдийн зураг, мэдээллийг хувийн фэйсбүүк хуудас ба бусад хувийн нийгмийн сүлжээн дээр тавих
- 5.2.11 Ажлын байр, хүүхдийн орчинд архи, тамхи мансууруулах эм бодис хэрэглэх

5.3. Компанийн ажилтан албан хаагч бүр дараах зүйлсийг хориглоно.

Үүнд:

- 5.3.1 Хүүхдийг цохих, зодох, тусгаарлах зэргээр бие махбодын хүчирхийлэл үйлдэх
- 5.3.2 Хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, дорд үзэх, нэр хоч өгөх, сэтгэл зүйн дарамт учруулах зэргээр сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх
- 5.3.3 Хүүхэд, гэр бүлийн эсрэг бүх төрлийн хүчирхийл үйлдэх
- 5.3.4 Бусдыг садар самуунд уруу татсан тоглоом тоглох, шалиг үг ярих
- 5.3.5 Хүүхдийн дэргэд хараал хэлэх, бүдүүлэг үг хэрэглэх
- 5.3.6 Хүүхдийг ялгаварлан харилцах
- 5.3.7 Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд мэдээлэхгүй орхих
- 5.3.8 Зохисгүй хувцаслах, бэлгийн дур сонирхол төрүүлэхүйц байдал гаргах
- 5.3.9 Чанарын баталгаагүй, муудсан, хориглосон, чихэрлэг хоол хүнсээр хангах
- 5.3.10 Хүүхдийн зураг, дүрс, мэдээллийг зөвшөөрөлгүй хувийн фэйсбүүк хуудас ба бусад хувийн нийгмийн сүлжээн дээр тавих
- 5.3.11 Шөнийн цагаар эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй хүүхдийг тээвэрлэх
- 5.3.12 Цахим орчинд эцэг эхээс нь далдуур хүүхэдтэй харилцах

8	Шинээр төрсөн /хүүхэд асрах чөлөөтэй ажилтанд / ээжид нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгох	Жилдээ	Б.Лхагвасүрэн
9	Эх үрсийн баярыг зохион байгуулах, 18 хүртэлх насны хүүхдэд бэлэг өгөх	6-р сард	ЗУХ, Эцэг эхийн зөвлөл
11	12-р анги төгсөх хүүхдэд гарын бэлэг гардуулах, хүлээж авах	6-р сард	ҮЭХ, Б.Лхагвасүрэн
12	Нийт эцэг эхчүүдэд хүүхэд хамгааллын чиглэлээр багш урьж "Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүмүүжлийн зэрэг арга, гэр бүлийн харилцааны чиглэлээр сургалт" авах	1-р сард	Б.Лхагвасүрэн
13	Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газартай хамтран зөвлөлийн гишүүдэд сургалт авах (Сургагч багш бэлтгэх)	2-р сард	Б.Чанцалням
14	Хүүхэд хамгааллын зөрчлийн талаар тогтмол мэдээлэл авах (зөвлөлийн гишүүд нууцлалыг чандлан хадгална)	Тогтмол	Б.Чанцалням
15	Эцэг эхийн ажилтай танилцах өдөрлөг зохион байгуулах	4-р сард	Б.Пүрэвхишиг
16	Ажилтнуудын гэр бүлийн бизнесийг дэмжих, сурталчлах чиглэлээр ажил зохион байгуулах	Тогтмол	Б.Энхтөр, Б.Лхагвасүрэн
17	Олон улс тив дэлхийн, улсын чанартай уралдаан тэмцээнд орлцож амжилт гаргасан хүүхдүүдэд байгууллагын нэрэмжит шагнал гардуулах	6-р сард	Б.Лхагвасүрэн
18	Зулзагын сувилалын газарт гэр бүлээрээ нэг өдөр амруулж, гэр бүлийн өдөрлөг зохион байгуулах (баг насны хүүхэдтэй 10 хүртэлх гэр бүлийг хамруулах)	Жилдээ	Б.Лхагвасүрэн
19	Миний аав, ээжийн ажил сэдэвт шторк аниме, гар зураг бүтээх уралдаан зохион байгуулах	Эхний хагас жилд	Б.Лхагвасүрэн Б.Чанцалням

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

"ДДС"ТӨХК-ИЙН ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б. Чанцалням

Б.ЧАНЦАЛНЯМ

“ДДС” ТӨХК-ИЙН ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Эцэг эхийн зөвлөл гэж (цаашид “Зөвлөл” гэх) нь “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийн хүрээнд компанийн ажилтнуудын хүүхдийн сурч боловсрох, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх, соён гэгээрүүлэх, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олныг бий болгоход дэмжих, хүүхэд хамгаалалын бодлогыг хэрэгжүүлэхэд хөндлөнгийн хяналт тавих, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшүүлэх үүднээс тухайн байгууллагаас эрх үүрэг хүлээж гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсгийг хэлнэ.

Хоёр. Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

- 2.1. Зөвлөл нь алба хэлтсийн төлөөллөөс бүрдсэн 9 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 2.2. Зөвлөл, зөвлөлийн гишүүд нь ажилтнуудаас санал авч, зөвлөлийн гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг гарган компанийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороотой зөвшилцөн /ХХТХуулийн 52.7-р заалт/ батлуулж, хэрэгжилтийг хангах үүрэг хүлээнэ.
- 2.3. Эцэг эхийн зөвлөл нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдах ба ажилтнуудаас ирүүлсэн хүсэлт, бусад шалтгаанаар шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт бус хурал зохион байгуулж болно.
- 2.4. Зөвлөлийн гишүүдийн гуравны 2-оос доошгүй ирцтэй үед зөвлөлийн хурлыг хүчин төгөлдөрт тооцож, асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх ба нарийн бичгийн дарга хуралдааны протоколыг хөтөлж, зөвлөлийн гишүүд танилцаж гарын үсэг зурснаар баталгаажна.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагаа

- 3.1. Зөвлөл нь байгууллагын ажилтан, албан хаагчдын гэр бүл, хүүхдийн судалгаанд үндэслэн тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг үе шаттай төлөвлөн зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, үйлдвэрлэл, бүтээгдэхүүнээр ажилчдын гэр бүлийн зөв харилцаа хандлага, хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх, хүүхдийн

- хөгжил, хамгааллыг дэмжих талаар удирдлагатай хамтран ажиллана. "ДДС" ТӨХК-нд хэрэгжүүлэх хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- 3.2. Байгууллагын ажилтнуудын эрүүл зөв амьдралыг дэмжиж, хүүхэд эцэг эхчүүдэд чиглэсэн тогтоол шийдвэр заавар зөвлөгөөг нийт ажилтан, албан хаагчидад мэдээлж сурталчлах ажлыг зохион байгуулна.
 - 3.3. Зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагааг мэдээллийн самбар цахим хуудсанд байршуулж, сурталчилна.
 - 3.4. Зөвлөлөөс гарсан санал, шийдвэрүүдийг удирдлагад танилцуулж шийдвэрлүүлнэ.
 - 3.5. Байгууллагын боломж, гэр бүл, хүүхдийн судалгаа, ажилтнуудын саналыг үндэслэн байгууллагын дэргэд хүүхдийн өдөр өнжүүлэх төв, цэцэрлэг байгуулж ажиллуулах, гэрээт өдөр өнжүүлэх, цэцэрлэгтэй хамтран ажиллах талаар компанийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран хөтөлбөр, зорилт боловсруулна.
 - 3.6. Байгууллагын онцлог ажилтнуудын хүүхдүүдэд чиглэсэн мэргэжил сонгох, ажил хөдөлмөрийн чиг баримжаа олгох, эцэг, эхийн ажилладаг ажлын байр, ажлын онцлог, давуу талыг нь танилцуулах, улмаар байгууллагыг нийгмэд эерэг байдлаар сурталчлах ажлыг үе шаттай зохион байгуулна.
 - 3.7. Ажилтнуудын хүүхдийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор цэцэрлэг, бага ангийн хүүхэдтэй эцэг эхчүүдэд Хөдөлмөрийн хуулийн дагуу богиносгосон цагаар ажиллах нөхцөл бүрдүүлэх, хүүхдийнхээ эцэг эхийн хуралд оролцох, эцэг эхийн эргүүл хийх боломжоор хангахад дэмжлэг үзүүлнэ.
 - 3.8. 0-18 насны хүүхэдтэй гэр бүлийг дэмжих төлөвлөлтийг жил бүр хийж хэрэгжүүлэхдээ албан хаагчдын дунд ярилцлага, хэлэлцүүлэг хийх, ажилтнуудын саналыг нээлттэй авах байдлаар зохион байгуулах
 - 3.9. Хүүхэд хамгааллын чиглэлээр хамтын гэрээнд нэмэлт санал оруулж тусгуулах

Дөрөв. Үр дүнг нэгтгэх, хянах, төсөв

- 4.1. Эцэг эхийн зөвлөлийн хийсэн ажлын тайланг жил бүр хамт олны хуралд танилцуулж санал, хүсэлт авч ажиллана.
- 4.2. Жилийн үйл ажиллагааны тайлангаа Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 12 дугаар сарын 01-ний дотор хүргүүлж байна.